

БАТЛАВ

"РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ"  
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ



С. ЦАГААНХҮҮ

БАТЛАВ

"АЛЬФА КАРБОН" ХХК-ИЙ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.АРИУНБОЛД

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022.06.20

№ АТ/20/38

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэнэ)-г нэг талаас "Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" Улсын Төсөвт Үйлдвэрийн Газрын Хангамж үйлчилгээний албаны дарга Э.Энхгэрэл (цаашид "Захиалагч" гэнэ), нөгөө талаас "Альфа карбон" ХХК-ний менежер М.Ган-Эрдэнэ (цаашид "Ажил гүйцэтгэгч" гэнэ) (цаашид хамтад нь "Талууд", тус тусад нь "Тал" гэнэ) нар Монгол улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

#### 1.Нийтлэг заалт

- 1.1 Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгын Бэлх, Налайхын сайтын засварын ажлыг гэрээнд заасан хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн эрх бүхий албан тушаалтанд тайлагнах, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Гүйцэтгэгчийн ажлын төсөв гэрээний салшгүй хэсэг байна.

#### 2.Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү Гэрээ нь 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг дуустал ажлын 10 хоногийн хугацаатай байна.
- 2.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

#### 3.Ажил үйлчилгээний төлбөр

- 3.1 Гэрээний дагуу ажил гүйцэтгэлийн хөлс 19 500 000 /Арван есөн сая таван зуун мянга/ төгрөг төгрөг байна.
- 3.1.1 Захиалагч тал энэхүү гэрээ баталгаажсан өдөр ажлын хөлсийг гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг үндэслэн Хаан банкны 5040244035 тоот дансанд шилжүүлнэ.

#### 4.Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1 Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

4.2 Гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.

4.3 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.

4.4 Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авсанаас хойш аливаа эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

4.5 Ажил гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан болон хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачлагаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

4.6 Захиалагч нь баталгаат хугацааны дотор ажлын үр дүнд доголдол илэрсэн тохиолдолд тухайн доголдолыг арилгуулахаар Ажил гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй.

#### 5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

5.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

5.3 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.

5.4 Дараахь тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:

- Ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн өгсөн зааварчилгаа, даалгавар нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;
- Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.
- Ажил гүйцэтгэгч нь өөрийн инженер техникийн ажилчдын ХАБЭА-г бүрэн хариуцаж ажиллана

5.5 Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах үүрэгтэй.

5.6 Захиалагчид өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх үүрэгтэй.

5.7 Ажлын үр дүн доголдолыг арилгахад шаардагдах зардлыг хариуцах үүрэгтэй.

5.8 Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасаны дагуу шаардах эрхтэй.

5.9 Ажил үйлчилгээний даалгаварын талаархи аливаа мэдээллээр хангагдах эрхтэй.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагч талыг төлөөлж:

Хангамж, үйлчилгээний албаны дарга

 /Э.Энхгэрэл/

Хаяг: БГДүүрэг 17-р хороо  
Утас : 75112020

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

"Альфа карбон" ХХК-ий менежер

 /М.Ган-Эрдэнэ/

Хаяг:  
Утас: 88282255